

Нийслэлийн Эрүүл Ахуй, Халдвар судлалын хяналтын алба

1921 он 08 сар 15-анд Цэргийн Зөвлөлийн хурлаар Төвд, Европ эмнэлгийн хороо байгуулж, Намын 2 дугаар их хурлаас хүн амын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийг хамгаалах бодлого чиглэлээ тодорхойлж, халдварт өвчинтэй тэмцэх тухай асуудлыг онцгойлон авч үзсэн байна.

1924 он. БНМАУ-ын "Үндсэн хууль" д хүний өвчин эмгэгийг анагаах засал, сэргийлэх дүрэм хэмжээг тогтоох" хэмээн урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн асуудлыг төр засгийн үүрэг болгон хувьчилсан.

1926-1927 он. Хүн амын Эрүүл мэндийн байдлыг судлах, халдварт өвчинтэй тэмцэх, нөлөөлж байгаа хүчин зүйлийг тогтоох зорилтыг хэрэгжүүлэхэд Зөвлөлт Орос улсын эмнэлэг-ариун цэврийн удаа дараагийн экспедиц чухал үүрэг гүйцэтгэсэн. / мөн онуудад эмнэлэг ариун цэвэр, халдвар судлалын алба байгуулах, ариун цэвэр, суртал ухуулгын ажил чухал болох талаар дүгнэлт гаргасан нь ариун цэвэр, халдвар судлалын алба үүсч хөгжихөд ихээхэн түлхэц өгсөн.

1929 он. Улаанбаатар хотод Иргэний больницыг түшиглэн анхны лабораторийг бактери судлалын засагтайгаар байгуулсан нь урьдчилан сэргийлэх мэргэжлийн байгууллагын анхны суурь бөгөөд, мөн энэ онд ДЯЯ-ны Ардыг Эрүүлийг хамгаалах газарт ариун цэврийн зааварлагчийн орон тоо батлагдаж, энэ орон тоон дээр ажиллаж байсан хүн нь Улаанбаатар хотын ариун цэврийн эмчийн үүргийг хавсран гүйцэтгэж байсан.

1929 онд Ардыг эрүүлийг хамгаалах газрын даргын 988 тоот тушаалаар цэцэг өвчний тарилгыг бүх нийтэд хийхээр шийдвэрлэсэн нь нийтийг хамарсан төлөвлөгөөг вакцинжуулалтын анхны арга хэмжээ болсон юм

1930 он. 05 сард ЗСБНМАУ-ын БНМАУ-ын хооронд "Ариун цэврийн конвенц байгуулагдаж, гоц халдварт аюулт өвчин, тухайлбал, тарваган тахал, булчин задрах тахал, шар чичрэг, цагаан цэцэг, хижиг өвчинтэй тэмцэх, сэргийлэх талаар хамтран ажиллахаар тохирсон. 10 сард Ардын Эрүүлийг хамгаалах яамны үүргийг өргөтгөн ухуулан таниулах болон халдварт өвчний хөл хориог зохион байгуулах үүрэг бүхий Ариун цэвэр урьдчилан сэргийлэх хэлтсийг шинээр байгуулсан нь эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны төрийн захиргааны төв байгууллагын суурь тавигдсан үе юм.

1931 оны 05 дугаар сард Ардын Эрүүлийг хамгаалах яамны харьяа ариун цэвэр, бактери шинжилгээний лабораторийг "Ариун цэврийн эрүүл ахуйн "Вакцин үйлдвэрлэл"-ийн гэсэн засагтайгаар байгуулан ажиллуулсан.

Мөн 1931 оны 06 дугаар сард "Ардыг Эрүүлийг хамгаалах яамны дүрмийг баталсан бөгөөд энэ дүрмийн 2 дугаар бүлэгт "Тус улсын дотор ариун цэврийн явдлыг хөгжүүлэн, аливаа халдварт өвчнөөс хамгаалах, хот хөдөөгийн нутагт ариун цэврийн асуудлыг хариуцах, хоолны зүйлийг хянах, халуун ус, үс засах газруудыг хянах, халдвар бүхий өвчнүүдийг эсэргүүцэх, ариун цэврийн байгууллага байгуулах худалдаа ба үйлдвэрийн газруудын доторх ариун цэврийг хянах, шинжлэх ажил явуулах, ариун цэврийн хэрэгт шаардлагатай зүйл"-ийг бэлтгэх мэтээр заасан байна.

1933 оны 03 дугаар сард БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 9 дүгээр хуралд ЭХЯ-ны сайд Ө.Бадрах "Ариун цэврийг хянан харгалзах явдлын төлөвлөгөө"-г хэлэлцүүлэн батлуулжээ. "Энэ төлөвлөгөөнд "Ариун цэврийн байдлыг байнга хянан харгалзахын тулд ариун цэврийн хянан харгалзах явдлыг байгуулж явуулна. гэж заасан бөгөөд энэ ажлыг орон нутагт эмнэлгийн салбарын эмч нар гүйцэтгэх, Улаанбаатар хотод ариун цэврийг хянан харгалзах дүрмийг баримтлан ажиллана гэж заасан байна. Энэ дүрэмд Улаанбаатар хотод ариун цэврийн хяналтыг энэ ажил хариуцсан мэргэжлийн эмч, түүний шууд мэдэлд байгаа ариутгах отряд, гүйцэтгэнэ, ариун цэврийн хяналт хийх ажил хотын захиргаанд харьяалагдана, ариун цэврийн эмч 3 сард нэг удаа гүйцэтгэсэн ажлаа хотын Захиргааны хуралд илтгэнэ, хорих газрын ариун цэврийг байнга хянаж байх, гудамж зээл, чөлөө, хашаа, түүний доторх ариун цэврийн байдлыг шалгаж байх, халдварт өвчний эх уурхай, голомтод шинжилгээ хийх, халдварт өвчнийг тусгаарлаж, ариутгах арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх тарилга хийх, ариун цэвэр гэгээрлийн ажил явуулах, эмчлэн сэргийлэх газруудын ариун цэврийг тогтмол хянах, ариун цэврийн талаа хор хөнөөлтэй байгаа худалдаа үйлдвэрийн газруудыг хотын захиргааны зөвшөөрөлтэйгөөр хааж байх эрх үүргийг ариун цэврийн эмчид олгох гэх зэргээр заасан байна.

1933 он. Улаанбаатар хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны тогтоол гарч, хотын гудамж, талбайг цэвэрлэх, усан сангийн хангамжийг сайжруулах, худаг гаргах зэрэг асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн оны 08 дугаар сард Сайд нарын зөвлөлийн хурлаас аймаг орон нутагт ариун цэврийн комисс ажиллуулахаар шийдвэрлэсэн байна.

1935 он. ЭХЯ-ны "Ариун цэвэр халдвар эсэргүүцэх хэлтэс" байгуулагдсанаар ариун цэвэр, халдвар эсэргүүцэх арга хэмжээг өргөн хүрээтэй явуулах боломж бүрдсэн бөгөөд халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажилд гол анхаарлаа хандуулах болжээ.

1938 онд СнЗ-ийн Ариун цэврийн комиссын ажлыг хүчтэй болгох, өргөн олныг хамарсан ариун цэвэр, гэгээрлийн ажил явуулах талаар тогтоол гарган, сурталчилгаанд зориулсан санамж, зурагт хуудас, сэтгүүл гаргахыг ЭМЯ-д даалгасны дагуу 1939 оноос "Эрүүл мэндийн төлөө" эхэлсэн байна.

1940 он СнЗ-ийн 31 дүгээр тогтоолоор Улсын ариун цэврийн улсын хяналтын анхны хууль, эрх зүйн баримт бичиг болсон юм. Уг дүр-мэнд ариун цэвэр, эрүүл ахуйн норм, дүрэм, зааврыг СнЗ-ийн баталсны дараа мөрдүүлэх, ариун цэврийн байцаагчид барилга байгууламж, үйлдвэр, ус, дулаан түгээх сүлжээнд хяналт тавих, хүний эрүүл мэндэд хор нөлөө үзүүлэх хортой, аюултай зүйлийн хадгалалт, борлуулалтад хяналт тавьж ариун цэврийн ном, дүрмийг зөрчигчдөд Улаанбаатар хотын хороодод ариун цэврийн комисс ажиллуулж, хот нийтийн цэвэрлэгээний өдрийг зохион байгуулах болж, айл бүрийг жорлон, угаадас хийх нүхтэй болгож, хотыг ногооруулах, гудамж зээлийг засаж тохижуулах арга хэмжээ авч байсан байна.

1942 он. Улаанбаатар хотын Бага хурлын Тэргүүлэгчдийн Эрүүлийг хамгаалах хэлтсийн дэргэд Ариун цэвэр, халдвар судлалын тасгийг байгуулсан нь Улаанбаатар хотын эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны суурь, анхны нэгж нь болсон бөгөөд хотын ариун цэврийн нөхцөл байдлыг сайжруулж, халдварт өвчинтэй тэмцэж, сэргийлэх ажлыг үр дүнтэй явуулахад энэ тасаг ихээхэн үүргийг гүйцэтгэсэн байна.

1943 он. 06 дугаар сард "Улаан суулга өвчнийг эсэргүүцэх тарилга хийх тухай" ЭХЯ-ны сайдын тушаал гарч, Улаанбаатар хотын бүх хүнийг 14 хоногт халдваргүйжүүлэлт

хийх, халдвартын эмч нарт унадаг дугуй 4-ийг олгох зэрэг асуудлыг шийдвэрлэсэн байна.

1944 он."Томуунаас сэргийлэх тухай" СнЗ-ийн тогтоолоор Улаанбаатар хотын нийтийн байр, техникум, сургуулиуд хлорын шохой ууршуулах, нойтон цэвэрлэгээ хийх, автобусны эцсийн буудалд ариутгал цэвэрлэгээ хийх, ариун цэвэр гэгээрлийн ажлыг өргөн зохиож байх арга хэмжээ авсан байна.

1945 он. нийслэл хотод гарсан дизентри хэмээх цусан чац-га, гэдэсний халуун хижиг /Тив/ өвчнөөс сэргийлэх тарилгыг 8-с дээш насны бүх хүмүүсийг хамруулан тарих шийдвэр гарган хэрэгжүүлсэн. Мөн оны 09 дүгээр сард "Хот сайжруулах араг хэмжээний тухай" Сайд Нарын Зөвлөлийн 69 дүгээр тогтоол гарч ариун цэврийн журам зөрчсөн яам, олон нийтийн байгууллагын эрх баригчид, ардуудыг торгож, шийтгэх эрхийг Хотын Захиргааны Хот сайжруулах хэлтэс, Ариун цэврийн тасагт олгосон байна.

1946 он. Хотын Эмнэлгийн хэлтсийн дэргэд ариутгагч бэлтгэх курс зохион байгуулан, 15 хүн төгсөж, хот хөдөөд хуваарилан ажиллуулах Бактери шинжилгээний газрын Химийн лабораторийг хотын эмнэлгийн хэлтсийн мэдэлд шилжүүлэн "Хими ба идэш уушны лаборатори" болгосон байна. Мөн оноос сүрьеэ гийн вакциныг Улаанбаатар хотод энх хэрэглэж эхэлсэн.

1947 он. "Талхны газрын ариун цэврийн хяналтыг сайжруулах тухай" ЭМС-ын тушаал гарч,Улаанбаатар хотын Талхан завод,Нарийн боовны үйлдвэр,Налайх болон бусад газруудын талх барих, тээвэрлэх, худалдаалах газрын ариун цэврийг 7 хоног тутам шалгаж байхыг Хотын Ариун цэврийн тасагт , ажилчдын ариун цэврийг 2 долоо хоногт шалгаж байхыг Эрүүлийг хамгаалах хэлтэст даалгасан байна.

1947 онд Хот сайжруулах ажлын явцын тухай СнЗ-ийн 31 дүгээр тогтоол гарч Улаанбаатар хотод Халуун усны газар байгуулах, хогийг заасан газарт, асгаж байх, ариун цэвэр сахиулахын тулд хороо бүрийг 5-ас доошгүй цагдаатай болгох асуудлыг шийдвэрлэсэн байна.

1948 оны 05 дугаар сарын 25-анд "Ажилчдыг эрүү мэндийн үзлэгт заасан үзүүлж байх тухай" СнЗ-ийн 159 дүгээр тогтоол гарсан бөгөөд энэ тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЭХЯ-ны сайдын 1948 оны 155 дугаар тушаал гарсан байна.

Энэ тушаалаар Улаанбаатар хотод Эрүүлийг хамгаалах хэлтсийн "Ариун цэвэр, халдвартын тасаг"-ийг "Халдварт ариун цэврийн станц" болгон өөрчлөн зохион байгуулснаар Улаанбаатар хотод Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын алба үүссэн байна. Энэ станц 42 орон тоотойгоор байгуулагдаж, анхны даргаар хүний их эмч Даш /гавьяат эмч/ томилогдон ажилласан байна.

1948 он. СнЗ-ийн тогтоолоор хотын ариун цэврийн байцаагчдын хяналтын ажилд зориулсан М-72 маркийн мотоцикл,50-иад унадаг дугуй олгож, байцаагчдыг унаажуулах арга хэмжээ авсан.

1949 он. ЭХЯ-ны сайдын 32 дугаар тушаалаар хотын Халдварт ариун цэврийн станцын төсөв, орон байр, аж ахуйн хувьд хотын эмнэлгийн хэлтэст, мэргэжлийн хувьд Улсын ариун цэвэр, шалган байцаах газарт харьяалуулсан ба 1950 онд гэхэд ариун

цэврийн хяналт, халдвар судлалын ажлыг Улаанбаатар хотын станцыг дагнан хариуцаж байсан байна.

ЭХЯ-ны сайдын 1950 оны 145 дугаар тушаал, халдварт өвчинтэй тэмцэж, сэргийлэхэд ариун цэвэр, гэгээрлийн ажил чухал болохыг заагаад, бүх их, бага эмч нар сард 6-гаас доошгүй хөдөлмөрийн цагийг ариун цэвэр, гэгээрлийн ажилд зориулж байх, энэ ажлыг хотын Халдварт, ариун цэврийн станц зохион байгуулж байх үүрэг болгосон байна.

1951 он. Ардын гэгээрэл, ЭХЯ-ны сайдын хамтарсан тушаалаар эрүүл ахуй, ариун цэврийн хичээлийг 1 ангид 8 цаг, 2 дугаар ангид 10 цаг 3 дугаар ангид 14 цаг хичээл орж байх асуудлыг шийдвэрлэн, 1951 оны 10 дугаар сараас Улаанбаатар хотын бүх сургуульд эхлүүлж, сургалтын материалаар хангах үүргийг хотын Халдварт, ариун цэврийн станцад даалгасан байна. Мөн онд Улсын ариун цэврийн байцаагч бэлтгэх курс зохион байгуулан Улаанбаатар хотын 10 хороонд Галсанцэрэн, Дамдиндорж, Пүрэв, Магсаржав нарын 10 хүнийг томилон ажиллуулсан байна.

1950 онд Хотын халдварт судлал, ариун цэврийн станц материаллаг бааз, мэргэжлийн боловсон хүчний хувьд нэлээд бэхэжсэн бөгөөд 1955 он гэхэд тус станц Хотыг Гүйцэтгэх захиргааны өмнө талд Хот тохижуулах хэлтэстэй хамт 4 өрөө байранд, Бактериологийн лаборатори нь төв нь төв больниц ийн ар талд жижиг модон байшинд үйл ажиллагаа явуулж байсан.

Бактериологийн лаборатори 1953 онд халдварт өвчнийг оношлох, урьдчилан сэргийлэх шинжилгээ хийх чиглэлээр байгуулагдсан бөгөөд 1959 он. эрүүл ахуйн их эмч Ж.Шагж хүнсний ариун цэврийн химийн, их эмч Ч.Дашням орчны эрүүл ахуйн лабораторийг тус тус санаачлан эх суурийг нь тавьжээ.

1955 он. Улаанбаатар хотын 10 хороонд ажиллаж байсан улсын байцаагчдыг хотын Халдварт ариун цэврийн станцад нэгтгэн Ариун цэврийн хэсэг, Халдвар судлалын хэсэг, Бактериологийн лаборатори гэсэн 3 хэсэгтэйгээр зохин байгуулан, ариун цэврийн хэсгийн бага эмч нарыг хүнс, худалдаа, нийгэм ахуйн үйлчилгээний чиглэлээр төрөлжүүлэн ажиллуулах болсон байна.

1956 он. СнЗ-ийн 419 дүгээр тогтоолын Улсын ариун цэврийн байцаан шалгах ерөнхий газрын дүрэм /2 дахь дүрэм/ батлагдсан ба энэ дүрэмд улсын ариун цэврийн байцаагчид бүх үйлдвэр, байгууллага, нийтийн ба амины орон сууц, хашааг саадгүй шалган үзэх, мөн хорих анги, лагерь зэрэгт ажлын цагаар шалгаж, үйлдвэр албан газар, байгууллагуудад ариун цэврийн тогтоосон норм, дүрмийг зөрчвөл үйл ажиллагааг нь түр зогсоох, хүний биед хор аюултай зүйлийг худалдаалахыг зогсоох битүүмжлэх, бүрмөсөн устгах гэх зэргээр ариун цэврийн байнгын хяналттай холбоотой асуудлуудыг заасан байна.

Мөн агаар, хөрс, усыг бохирдлоос хамгаалах, барилгын зураг, төлөвлөгөөг зохиох, барилгын газар, сонгох, ашиглалтад хүлээн авах зэргээр урьдчилан хяналттай холбоотой заалтуудыг тусгасан байна.

1960 онд СнЗ-ийн 170 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын станцыг Улаанбаатар хотын АДХГЗ-нд харьяалуулсан бөгөөд энэ үед тус станц ариун цэврийн

төрөлжсөн хяналт хийхийн зэрэгцээ ариун цэврийн хяналтын бага эмч, лаборант, ариутгагч нарыг сургах, мэргэжил олгох, дээшлүүлэх үүргийг гүйцэтгэж байсан.

1961 он. Хотын Халдварт, ариун цэврийн станц 50 орон тоотой, үүнээс их эмч 13, бага эмч 9, лаборант 11, бусад ажилтан 7, захиргааны ажилтан 10 ажиллаж, жилийн төсөв нь 420,0 мянган төгрөг байжээ.

1963 он. Улаанбаатар хотын станцын хортон устгах товчоог хортон устгалын салбар болгон өргөтгөж, аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулж, урьдчилан сэргийлэх ариутгал устгалын ажлыг энэ салбараар хийлгэж, хөлсийг нь цаг тухайд нь төлж байх асуудлыг албан байгууллагын дарга, эрх баригчдад даалгасан СнЗ-ийн тогтоол гарч байжээ.

Ариун цэвэр урьдчилан сэргийлэх ажлын тухай Намын төв хороо, СнЗ-ийн хамтарсан 23/22 дугаар тогтоол гарч Улаанбаатар хотын Ариун цэвэр, халдвар судлалын станц байртай болсон тухай тэмдэглэн

1964 он. багтаан салбар станц байгуулах шийдвэр гаргасан байна. Энэ шийдвэрийн дагуу Улаанбаатар хотын Налайх дүүрэгт 1 их эмч 2 бага эмч, 1 лаборант, ариутгагч, бүгд 6 хүний орон тоотой АЦХСС байгуулагдсан байна.

1965 он. Улаанбаатар хотын хог хаягдлыг зайлуулах цэг тогтоох, нийслэл, дүүргийн замын дагуу асгасан хог хаягдлыг цэвэрлэх, хотын албан газар, байгууллага орчныхоо 50 метрийн газрыг цэвэрлэж байх асуудлыг шийдвэрлэх

1967 он. "Хүнсний үйлдвэрийн ариун цэврийг сайжруулах арга хэмжээний тухай" НТ Хороо, СнЗ-ийн 28/380 дугаар тогтоол гарч хүнсний үйлдвэрийн ариун цэвэр, соёлжихыг сайжруулах үүргийг аймаг, нийслэлийн удирдлагад өгсөн байна.

1969 он. Хотын АЦХСС барилга, байгууламжийн урьдчилсан хяналт хийж эхэлсэн ба 1970 оноос хотын объектуудыг ариун цэврийн хяналтын карттай болгож жилд нэг объектыг 3-4 удаа шалгаж байх журам тогтоон, ариун цэврээр сайн объектуудыг шалгаруулан дүгнэдэг болжээ.

1970 он. АЦХСС эрүүл ахуйн болон халдвар судлалын мэргэжлийн групп, ариутгал, хортон устгалын товчоо, бактериологийн нэгдсэн лабораторитойгоо ариун цэврийн урьдчилсан болон байнгын хяналт хийх, гадаад орчин, хөдөлмөр ахуйн нөхцөлийг эрүүлжүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх судалгаа, шинжилгээ хийх, ариун цэврийн олон нийтийн хяналтыг хүчтэй болгох, хөдөлмөрчдийн ариун цэвэр, соёлын хэмжээг дээшлүүлэхэд ажлаа чиглүүлж байжээ.

1980 он "Багануур районы талаар авах зарим арга хэмжээний тухай" СнЗ-ийн 49 дүгээр тогтоол гарч, тус дүүрэгт АЦХСС байгуулагдсан бөгөөд энэ нь Нийслэл хотын 2 дахь АЦХСС болсон байна.

1983 он. Улаанбаатар хотын тохижилт, ариун цэврийг сайжруулах арга хэмжээний тухай СнЗ-ийн 29 дүгээр тогтоол гарч, энэ тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор хотын АДХГЗ-ны 79 дүгээр тогтоолоор Сүхбаатар, Найрамдал, Ажилчин, Октябрийн районд АЦХС-ийн даргаар С.Наряд, Ажилчин районы АЦХСС-ын даргаар Ц.Амьтан, Октябрийн районы АЦХС-ын даргаар Ё.Лхагва, нарыг тус тус томилсон байна.

1987 он. Улаанбаатар хотын АЦХСС эрүүл ахуй, халдвар судлал, лаборатори, халдварт өвчний түргэн тусламж, халдваргүйжүүлэлт гэсэн үндсэн тасагтай, 100 гаруй эмч байцаагч, лаборант, бага эмч, ажилтнуудтай, мөн Сүхбаатар, Найрамдал, Ажилчин, Октябрь, Налайх, Багануур, гэсэн 6 дүүрэгт АЦХСС-тай тэнд 70 гаруй эмч ажилладаг болжээ.

1980-1990 он Хот, дүүргийн АЦХСС орчны ариун цэврийг сайжруулах, халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр гарсан хууль, тогтоомжийг сахиулах, хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа нийгэм, ахуй, орчны сөрөг нөлөөллийн шалтгаан, арилгах арга замыг судлах, эрүүл ахуйн үндэсний норм, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэх зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэж, шинээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, барилга байгууламж барих, техник технологи нэвтрүүлэхэд мэргэжлийн дүгнэлт гаргаж, хүн амын дунд халдварт өвчин гарахаас сэргийлэх, дархлаажуулах, эрүүл мэндийн боловсрол олгох, сурталчлах ажлыг зохион байгуулж байжээ.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар Улаанбаатар хотын засаг захиргааны зохион байгуулалт өөрчлөгдөн 12 дүүрэгтэй болсон бөгөөд энэ өөрчлөлттэй холбоотойгоор 1992 оны 12 дугаар сард Нийслэлийн Засаг даргын А/75 дугаар захирамжаар шинээр байгуулагдсан. Чингэлтэй, Сонгино хайрхан, дүүргүүдэд Эрүүл ахуй, халдвар судлалын хэсгүүдийг байгуулсан ба Улаанбаатар хотын АЦХСС-ыг Нийслэлийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газар гэж нэрлэсэн байна.

Нийслэлийн Засаг даргын дээрх захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор 1993 оны 01 дүгээр сард Нийслэлийн ЭМГ-ын даргын 02 дугаар тушаал гарч ЭАХС-ын хяналтын газрын даргаар Ч.Үржээг томилон, газрын дүрмийг батлан шинээр байгуулагдсан. Чингэлтэй, Сонгино хайрхан дүүргүүдэд ЭАХС-нд Нийслэлийн хяналтын албанаас 6 их эмч, 3 бага эмч, Хан-Уул, Баянзүрх дүүрэгт 2 их эмч, 1 бага эмч, бүгд 8 их эмч, 4 бага эмчийг орон тоо төсөв, тэдний эзэмшиж байсан эд аж ахуйг хамт шилжүүлсэн байна.

1994 он. "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" ЗГ-ын 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан А/110 А-183 дугаар тушаал, захирамж гарч Халдварт өвчин судлалын Улаанбаатар хотын үйлчилгээ хариуцсан хэсгийг Нийслэлийн ЭАХС-ын хяналтын газартай нэгтгэн Нийслэлийн ЭАХСТөв болгон зохион байгуулж, захирлаар нь Ч.Үржээг орлогч захирлаар Н.Дондогийг томилон ажиллуулсан. Дээрх шийдвэрийн дагуу НЭХСТөв нь нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрт Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналт, халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлдэг мэргэжлийн байгууллага болсон байна.

1995 он. Нийслэлийн ЭАХСТөв нь эрүүл ахуй, халдвар судлалын дуудлага тусгаарлалтын, эмчилгээ хяналтын /Диспансерийн/ эрүүл зүйн хими бактериологийн гэсэн үндсэн тасагтай, мэдээлэл санал хүсэлт барагдуулах хэсэг халдваргүйжүүлэлтийн хэсэгтэй, ЭАХС-ийн мэдээллийн бие даасан "Цагаан зараа" сонины редакцтай, 150 гаруй орон тоотой 18 сая төгрөгийн төсөв, хяналт шинжилгээ явуулах голомтын үйлчилгээний 2 автомашин тайгаар үйл ажиллагаа явуулж байжээ.

1995 он Дүүргийн ЭАХС-ын албаны материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор Нийслэл дүүргийн Засаг даргын захирамж гарч дүүргийн хяналтын албадыг эрүүл зүйн

хими, нян судлалын лабораторийг болгох асуудалд шийдэгдсэн бөгөөд энэ шийдвэрийг 1995-1996 онд бүрэн хэрэгжүүлж, нийслэлийн бүх дүүргийн хяналтын албад лабораторитой болсон.

1995 оны сүүлчээр нийслэл, дүүргийн ЭАХС-ын байгууллагуудын дэргэд хортон, шавьж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн хэсгийг аж ахуйн тооцоон дээр ажиллуулсан нь халдварт өвчинтэй тэмцэх, халдварт өвчний дамжих замыг таслан зогсооход ихээхэн ач холбогдолтой болсон байна.

1996 он 08 дугаар сард "Хөтөл"-д гарсан хол-ер өвчин богино хугацаанд тархан, халдвар Улаанбаатар хотод зөөрлөгдөн ирсэн 35 хүнийг өвчлүүлсэн. Энэ өвчний халдварын судалгааг хийж, уг өвчинтэй тараахгүйгээр таслан зогсоох үүргийг Нийслэлийн ЭАХС Хяналтын төв, дүүргийн ЭАХС-ын хяналтын албад хүлээж энэ үүргээ амжилттай хэрэгжүүлсэн.

1997 он нийслэл дэх эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай ЭМНХ-ын сайд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хамтарсан А/08, А/6 дугаар тушаал захирамж гарч, Нийслэлийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын төвийг алба болгон зохион байгуулж, тус халдварт өвчинтэй тэмцэх үүрэг бүхий хэсгийг шинээр байгуулагдсан Халдварт өвчин судлалын төвд нэгтгэн, нийслэл, дүүрэг зөвхөн Эрүүл ахуй халдвар судлалын хяналтын хэсэг, эрүүл зүйн лаборатори үлдсэн байна. Мөн энэ онд нийслэл, дүүргийн улсын байцаагчдыг төрийн албаны шалгалтад оруулж, тангараг өргүүлэн төрийн захиргааны албан хаагч болгосон.

1998 он. Нийслэлийн хүн амын усан хангамж, хоол тэжээл, хүнсний аюулгүйн байдал, хөрс, усны бохирдол, хүн амын эрүүл мэндийн боловсрол амьдралын хэв маяг, эрүүл мэндийн боловсрол, амьдралын хэв маяг, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ зэрэг нийгэм, эдийн засаг, орчны асуудлыг хамруулсан "Эрүүл хот" хөтөлбөр батлагдаж, энэ хөтөлбөрийн хүрээнд "Эрүүл ажлын байр" "Эрүүл хороо" "Эрүүл мэндийг дэмжигч сургууль" гэх мэт төсөл дэд хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн.

2001 он Эрүүл мэндийн сайд, нийслэлийн Засаг даргын хамтарсан 98/197 дугаар тушаал, захирамжаар Нийслэлийн ЭАХС-ын албыг Нийслэлийн Эрүүл мэндийн хяналтын алба болгон зохион байгуулж, Ш.Үдэнборыг даргаар нь томилж, эм, биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагчийг орон тоогоор ажилуулж эхэлсэн байна.

2002 он. МУИХ "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" 58 дугаар тогтоол гарч Монгол улсын ерөнхий сайдын харьяанд тохируулагч агентлаг Улсын мэргэжлийн хяналтын газрыг байгуулсан.

2003 он 01 дүгээр сард "Мэргэжлийн хяналтын байгууллагын зохион байгуулалтын тухай" нийслэлийн Засаг даргын 39 дүгээр захирамж гарч, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Мэргэжлийн хяналтын газрыг Тамгын хэлтэс, Санхүүгийн хяналт, шалгалтын хэлтэс, Нийгэм эрүүл мэндийн хяналтын хэлтэс Байгаль орчин, дэд бүтцийн хяналтын хэлтэс, Төв лабораторитойгоо байгуулан газрын даргаар Г.Галсанпунцагийг томилсон байна. Тус газрын Эрүүл мэндийн хяналтын алба, дүүргийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албанд ажиллаж байсан бүх байцаагчид ажиллахаар томилогдсон бөгөөд хэлтсийн даргаар Л.Бямбасүрэн томилогдон ажилласан.

НМХГ-ын даргын 2006 он 02 дугаар сарын 16-ны өдрийн 21 дүгээр тушаалаар газрын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан бөгөөд энэ тушаалаар Нийгэм эрүүл мэндийн хяналтын хэлтсийг Эрүүл мэнд, боловсролын хяналтын хэлтэс болгон, хэлтсийн даргаар Н.Хишигтийг томилон, Эрүүл ахуй, халдвар судлалын эм, био бэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын, боловсрол, соёлын хяналтын гэсэн 3 тасаг-тайгаар зохион байгуулж, мэргэжлийн чиглэлээр 7 баг болон ажиллах болсон байна. Одоо тус хэлтэст хүнсний эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 23 улсын байцаагч, орчны эрүүл ахуйн чиглэлээр 8 улсын байцаагч, хүүхэд өсвөр үеийн эрүүл ахуйн чиглэлээр 6 улсын байцаагч, халдвар судлалын хяналтын чиглэлээр 6 байцаагч, эмч био бэлдмэлийн чанарын хяналтын чиглэлээр 6 улсын байцаагч ажиллаж, Эрүүл ахуй, халдвар судлал, эм био бэлдмэл, эмчилгээний чанар, боловсрол, соёлын чиглэлээр мэргэжлийн хяналтыг нийслэлийн хэмжээнд тавьж байна. НЭМГ, Мэргэжлийн хяналтын газар нийслэл дэх эрүүл мэндийн байгууллагуудын эмчилгээ үйлчилгээ, эм хангамж, дотоод халдвар, стандартын шаардлагыг сайжруулахад үр дүнтэй хамтран ажиллаж байна.